



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/314

Булган сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Ганбаатар (ГЮ62050513)-ын Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 1 дүгээр гудамж 136 тоотод байршилтай 6308003605 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 594 м2 газрын зориулалтыг нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2. Д.Ганбаатартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтийн байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/144 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ